



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/323

Мөрөн сум

Хурдан морины бүсийн уралдааны
хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны А/44 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг үндэслэн аймгийн тахилгатай “Цагаан –Чулуут овооны тахилга наадам”-ыг зохион байгуулах болсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/159 дүгээр захирамжаар батлагдсан аймгийн хэмжээнд 2023 онд зохион байгуулах “Хурдан морины бүсийн уралдаан”-ны хуваарьт хавсралтад заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулж баталсугай.

2. Аймгийн тахилгат “Цагаан чулуутын овооны тахилга”-ыг зохион байгуулахдаа хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулагчийн зүгээс онцгой анхаарч холбогдох байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж, хяналт тавьж хамтран ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (хурандаа А.Алтанцоож), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), Арбулаг сумын Засаг дарга (Б.Гантулга), аймгийн Морин спорт уяачдын холбоо, Арбулаг сумын Морин спорт уяачдын салбар холбоонд тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

